



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f [facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
globe <http://rtcc.mrt.d.gov.mn>
envelope info@rtcc.mrt.d.gov.mn
phone [+976 77244409](tel:+97677244409)


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2019 оны 01-р сарын дугаар



“ГТХЗНТ” УТУГ нь 2019 оныг “хувь хүний хөгжил, мэргэшил, чадварыг дэмжих жил” болгон зарлалаа.

Хөдөлгөөн зохицуулалтын төвийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх мэдлэг чадвар, ёс суртахуун, бүтээлч, санаачлагатай ажилтныг үр бүтээлтэй тогтвортой ажиллуулах байгууллага болон хөгжих зорилгын хүрээнд “ГТХЗНТ” УТУГ-ын захирлын А/01 дугаартай тушаалаар 2019 оныг **“ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, МЭРГЭШИЛ, ЧАДВАРЫГ ДЭМЖИХ ЖИЛ”** болгон зарлалаа.



2018 оны үйл ажиллагааны тайлангаа ЗТХЯ-ны удирдлагад танилцуулав.



Зам, тээврийн хөгжлийн сайд, төсвийн ерөнхийлөн захирагчтай “ГТХЗНТ” УТУГ-ын захирал, төсвийн шууд захирагчийн 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн болон Төвийн үйл ажиллагааны тайланг танилцуулав. 2018 оны Хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үр дүнгийн

гэрээнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийн тайлан хамгаалалт хийж, 2019 оны үр дүнгийн гэрээнд оруулах ажлуудын төлөвлөгөөг боловсруулаад Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.



Төмөр замын салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог сайжруулахаар Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтран ажиллаа.

ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын дарга А.Батболд, ахлах мэргэжилтэн Ж.Булганхүү, ТМССХ-ийн дарга Б.Энхжаргал, “МТЗ” ТӨХК-ийн хуульч н.Удвал нарын хамт салбарын мэргэжилтэй ажилтан болон мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой Төмөр замын тээврийн тухай шинэчилсэн хуулийн төсөлд



санал боловсруулан хамтарч ажилласан. ТМССХ-ийн дарга Б.Энхжаргал төмөр замын салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог сайжруулах, салбар зөвлөл, дэд зөвлөлийн ажлын чиг үүргийг тодорхойлох танилцуулга хийсэн.



Хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, улсын бүртгэлд хамруулах үйл ажиллагааг тогтмол явуулан ажиллаж байна.

Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, бүртгэх чиг үүргийн хүрээнд “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг судлан үзээд, 8 вагонд шинээр дугаар олгосон. Хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, бүртгэхтэй холбоотой ISO 6346 “Ачааны чингэлэг-Кодчилол, нэгдсэн дугаарлалт, тэмдэглэгээ”; ISO 668:2013 “Ачааны чингэлгийн ангилал, хэмжээс жин” стандартуудыг судалан ажиллаж байна.



Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийж байна.

Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийн хүрээнд суурь бүтцийн 2019 оны 01-р сарын тасалдлын мэдээг хүлээн авч, тайлан боловсруулсан.



Галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

- “УБТЗ” ХНН-т 2018 онд галт тэрэгний хөдөлгөөн саатсан, осол, зөрчил гарсан шалтгаанд судалгаа хийж, боловсруулж тайлан мэдээг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-д хүргэсэн.

- Төмөр замын суурь бүтцүүдийн тээх, нэвтрүүлэх чадварын тооцоо, судалгааг хийж ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-д 2019 оны 01-р сарын 21-ний өдрийн 19 тоот албан бичгээр хүргүүлсэн.



Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогыг хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.



2018 оны 12 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtd.gov.mn, төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.



Төмөр замын холбогдолтой гадаад улсын сэтгүүлийн 01-р сарын дугаарыг төвийн цахим хуудсанд байршууллаа

Гадаад орнуудын төмөр замын салбартай холбоотой “Railway Magazine”, “Trains” сэтгүүлийн 01-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.





Төвийн ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэхээр сургалтад хамрууллаа.



МОНГОЛЫН УЛСЫН
БҮЛЭГ
ЭРХЭМ
ТӨСӨЛ
МОНГОЛЫН
УЛСЫН
БҮЛЭГ
ЭРХЭМ
ТӨСӨЛ

СОНИРХОН

Төвийн авлига, ашиг сонирхлын эсрэг 2019 оны төлөвлөгөөний дагуу **“АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЭСРЭГ УРИАЛГА”**-ыг гарган ажилтнуудыг уриалж ажилласан.

2019.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийг сурталчлан төвийн мэргэжилтнүүдийн дунд сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулсан.



“Хөдөлмөрийн тухай хуулийг сурталчлах нь: Хөдөлмөрийн гэрээ байгуулахад анхаарах асуудал”, “Мэдээллийн сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Стандартын төслийн орчуулга, баримт бичгийг боловсруулав

“ТВ 10031-2009 Төмөр замын ачааны вагон үйлдвэрлэл, засвар барилга байгууламжийн зураг төслийн шаардлага” стандартын орчуулгын төсөлд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын саналыг тусган засварлан боловсрууллаа.

“ГОСТ 33435-2015 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах удирдлага, хяналтын төхөөрөмж, Аюулгүй байдалд тавигдах шаардлага, хяналтын арга”, “O+P 941 Төмөр замын мэдээллийн сан, мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал” стандартын орчуулгын төсөлд төмөр замын байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэж боловсруулан саналыг төсөлд тусган засварлан боловсруулсан.

ISO 6346 “Ачааны чингэлэг-Кодчилал, нэгдсэн дугаарлалт, тэмдэглэгээ” стандартыг орчуулан боловсруулсан.

“ОСЖД-ийн 2019 онд зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөө”-г орчуулан боловсруулсан.



Удирдлага, хяналтын төв байгуулах суурь судалгааг хийж эхэллээ.




Төвийн 2018 оны 12-р сарын 26-ны А/80 тушаалаар батлагдсан Галт тэрэгний хөдөлгөөнийг хянах өрөөнийг төслийг боловсруулж, танилцуулах ажлын хүрээнд:

- Ажлын хэсгийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.



- Улаанбаатар хотын замын хөдөлгөөн удирдлагын төв, “УБТЗ” ХНН-ын захиран хувиарлах хэлтэс, ШУТИС-ын МХТСургууль, Үндэсний мэдээлэл технологийн компаниудтай очиж танилцан, мэдээлэл цуглуулж ажилласан.

- Үндэсний үүрэн опертар “ЖиМобайл” ХХК, “Юнител” ХК-тай уулзалт зохион байгуулж, төвийн үйл ажиллагааны талаар танилцуулж, хамтран ажиллах санал тавьсан.




2019 оны 1 дүгээр сард зорчигч тээвэрлэлт 207.2 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 0.9%-аар буурсан, ачаа тээвэрлэлт нь 2328.4 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.

ИНФОГРАФИК




Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2019 оны нэгдүгээр сард 207.2 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2328.4 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Ачилт- ачааны төрлөөр /2019 оны 1 дүгээр сард/




Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/




Дамжин өнгөрсөн ачаа 2019 оны нэгдүгээр сард 289.4 мян.тн ачсан байна.

Ачилтаар 2019 оны нэгдүгээр сард нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал, барилгын материал, жонш, нефтийн бүтээгдэхүүн өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1785.9 мян.тн ачсан байна.





 8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

